

ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗАР

62173 Арвайхээр, Өвөрхангай аймаг,
Утас: 70-32-22-88, Факс: 70-32-21-95,
E-mail: uvurkhangai_emg@moh.mn

ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН
ЗАХИРАЛ, ДАРГА НАРТ

2016.12.05. № 625
танай _____-ны № _____-т

Мэдээлэл хүргүүлэх тухай


Эрүүл мэндийн газрын даргын 2016 оны 12-р сарын 02-ны өдрийн 33 дугаар тушаал, “Эрүүл мэндийн газраас шагнал, урамшуулал олгоход мөрдөх журам” болон эрүүл мэндийн салбарын шинэ жилийн сүлд модны наадам зохион байгуулах болсон той холбогдуулан дараахь мэдээллүүдийг хүргүүлж байна.

Эрүүл мэндийн салбарын шинэ жилийн сүлд модны наадам 2016 оны 12 дугаар сарын 25-ны өдөр болох бөгөөд оролцох хүмүүсийн нэрсийг 2016 оны 12 дугаар сарын 16-ны дотор УТСХ-ийн хүний нөөцийн сургалт хариуцсан мэргэжилтэн /Н.Төгс-Очир/-д утсаар /88324000,99881803/ ирүүлнэ үү. Сүлд модны наадмын таксийг оролцогч өөрсдөө хариуцах бөгөөд урьдчилан бэлнээр ЭМГ-ын санхүүд төлсөн байна.

Хамрах хүрээ:

- БОЭТ – 20
- Хархорины нэгдсэн эмнэлэг- 10
- Сум дундын эмнэлэг, сум, өрхийн ЭМТ тус бүрээс - 2
- Зооноз өвчин судлалын төв-2
- Хувийн хэвшлийн ортой эмнэлэг тус бүрээс-2
- Хөх манал хувийн уламжлалт эмнэлэг- дарга -1
- Хувийн хэвшлийн үүдэн эмнэлгүүдийн төлөөлөл-10,
- Эм ханган нийлүүлэх байгууллагын төлөөлөл-3
- Эмийн сангийн төлөөлөл-8
- Рашаан сувилал тус бүрээс-2
- Мэргэжлийн хяналтын газар-2,
- Сургууль, цэцэрлэгийн эмч нар – 6,
- Цагдаа,цэргийн анги, шүүхийн шийдвэр -3 мэргэжилтэнүүдийг тус тус оролцуулахаар төлөвлөлөө.

Мөн эрүүл мэндийн салбарын оны шилдэгүүд тодруулах тул “Эрүүл мэндийн газраас шагнал, урамшуулал олгоход мөрдөх журам”-ын болзлыг хангаж, салбарын хэмжээний шалгаруулалтад шалгарах боломжтой ажилтнуудыг хамт олноороо хэлэлцэн, тодорхойлолт, материалыг 2016 оны 12 дугаар сарын 16-ны дотор ЭМГ-ын Хяналт, шинжилгээ үнэлгээ, мэдээллийн хэлтэст ирүүлнэ үү.



Д.ШИВААНҮРДЭВ

ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2016 оны 02 сарын 02 өдөр

Дугаар 9/33

Арвайхээр


Журам шинэчлэн батлах тухай

Эрүүл мэндийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.7 дугаар заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. “Эрүүл мэндийн газраас шагнал, урамшуулал олгох журам”-ыг хавсралтаар шинэчлэн баталсугай.

2. Журмыг хэрэгжүүлж ажиллахыг Удирдлага төлөвлөлт санхүүгийн хэлтэс /С.Энхжаргал/, Хяналт шинжилгээ үнэлгээ мэдээллийн хэлтэс /Н.Оюунтуяа/ нарт үүрэг болгосугай.

ДАРГА



Д.ШИВААНҮРДЭВ



ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРААС ШАГНАЛ, УРАМШУУЛАЛ ОЛГОХОД МӨРДӨХ ЖУРАМ

Эрүүл мэндийн салбарын хөгжил, хүн амд үзүүлэх эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд үр бүтээлтэй ажиллаж, өндөр амжилт гаргасан эрүүл мэндийн байгууллага, ажилтнууд болон эрүүл мэндийн салбарын хөгжилд үнэтэй хувь нэмэр оруулж, дэмжлэг үзүүлсэн төрийн ба төрийн бус байгууллага, хувь хүнийг шагнах, урамшуулахад энэхүү журмыг мөрдөнө.

А. ШАГНАЛ

Нэг. Шагналын төрөл

- 1.1 Эрүүл мэндийн газрын “Хүндэт тэмдэг”
- 1.2 Аймгийн “Эрүүл мэндийн тэргүүний ажилтан” цол тэмдэг
- 1.3 Эрүүл мэндийн газрын “Жуух бичиг”
- 1.4 Эрүүл мэндийн салбарын “Оны шилдэг ажилтан”
- 1.5 Эрүүл мэндийн салбарын “Оны шилдэг байгууллага”
- 1.6 Эрүүл мэндийн газрын “Хүндэт өргөмжлөл”

Хоёр. Шагнал олгох болзол

2.1. Шагналыг шат дараалан давхардуулахгүйгээр олгох бөгөөд ажлын амжилт, бүтээл нь өмнөх түвшингээс ахисан нөхцөлд дараагийн шагналд нэр дэвшүүлнэ. Онцгой амжилт гаргасан тохиолдолд ЭМГ-ын даргын шийдвэрээр шагналыг болзол харгалзахгүйгээр олгож болно.

2.2. Эрүүл мэндийн газрын шагналыг дараахь төрлөөр шалгаруулж, олгоно.

2.2.1. ЭМГ-ын “Хүндэт тэмдэг”-ээр дор дурдсан болзлыг хангасан эмч мэргэжилтэн, ажилчдыг шагнана.

- Төрийн албан хаагчийн болон эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээг баримтлан ажиллаж ёс зүйн зөрчил, мэргэжлийн алдаа дутагдал гаргаагүй

- Үйл ажиллагаа, мэргэжлийн түвшингээрээ байгууллага хамт олноо манлайлан ажилласан
- Хариуцсан ажлын үзүүлэлт сүүлийн 3-5 жилд аймгийн дундаж түвшингээс дээш байсан
- “Аймгийн эрүүл мэндийн тэргүүний ажилтан” цол тэмдгээр шагнагдаад 3-с доошгүй жил үр бүтээлтэй ажилласан

2.2.2. Эрүүл мэндийн салбарыг хөгжүүлэх, бэхжүүлэх, эрүүл мэндийн тусламж үйлчилгээг чанар, хүртээмжтэй хүргэх, эмч мэргэжилтнийг сургаж чадавхижуулах, тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд дорвитой хувь нэмэр оруулж, дэмжлэг үзүүлсэн төрийн ба төрийн бус байгууллага, олон улсын байгууллагын ажилтан ажиллагсад, хувь хүнийг ЭМГ-ын даргын шийдвэрээр **“Хүндэт тэмдэг”**-ээр шагнана.

2.2.3. **“Аймгийн эрүүл мэндийн тэргүүний ажилтан”** тэмдгээр дор дурдсан болзлыг хангасан эмч мэргэжилтэн, ажилчдыг шагнана.

- Төрийн албан хаагчийн болон эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээг баримтлан ажиллаж ёс зүйн зөрчил, мэргэжлийн алдаа дутагдал гаргаагүй
- Үйл ажиллагаа мэргэжлийн түвшингээрээ байгууллага хамт олноо манлайлан ажилласан
- Хариуцсан ажлын үзүүлэлт сүүлийн 3-5 жилд аймгийн дундаж түвшингээс дээш байсан
- ЭМГ-ын “Жуух бичиг”-ээр шагнагдаад 3-с доошгүй жил үр бүтээлтэй ажилласан

2.2.4. ЭМГ-ын **“Жуух бичиг”**-ээр дор дурдсан болзлыг хангасан эмч мэргэжилтэн, ажилчдыг шагнана.

- Төрийн албан хаагчийн болон эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээг баримтлан ажиллаж ёс зүйн зөрчил, мэргэжлийн алдаа дутагдал гаргаагүй;
- Үйл ажиллагаа мэргэжлийн түвшингээрээ байгууллага хамт олноо манлайлан ажилласан;
- Хариуцсан ажлын үзүүлэлт сүүлийн 3-5 жилд аймгийн дундаж түвшингээс дээш байсан;
- Эрүүл мэндийн салбарт 2-с доошгүй жил ажилласан;

2.3. Эрүүл мэндийн салбарын “Оны шилдэг ажилтан”:

Тухайн жилд онцгой амжилт гаргаж, уг журмын болзолыг хангасан, төрийн болон хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудаас дараахь “оны шилдэг” ажилтнуудыг шалгаруулж, өргөмжлөл, үнэ бүхий зүйлээр шагнана.

2.3.1. **“Оны шилдэг эрүүл мэндийн менежер”**-ээр дор дурдсан болзлыг хангаж, байгууллагын үйл ажиллагаа нь аймгийн хэмжээнд тэргүүлсэн эрүүл мэндийн байгууллагын менежерийг шалгаруулна

- Эрүүл мэндийн талаар төрөөс баримтлах бодлого, Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, аймгийн нийгэм эдийн засгийг хөгжүүлэх үндсэн чиглэлийг хэрэгжүүлэхэд идэвх санаачилгатай ажиллаж, үр дүнг тооцсон байх
- Удирдлагын шинэ арга барилыг ажилдаа нэвтрүүлж үр дүнд хүрсэн байх
- Хариуцсан байгууллагын ажил нь тухайн жилд сайжирч, тодорхой ахиц гарсан байх
- Батлагдсан төсвийн хөрөнгийг төсвийн хуулийн дагуу зөв зарцуулж, өр авлагагүй ажилласан байх
- Байгууллагын эмч мэргэжилтнүүд сургалтанд жигд хамрагдан тухайн жилийн кредитээ бүрэн биелүүлсэн байх
- Байгууллага хамт олноороо ёс зүйн алдаа зөрчилгүй ажиллаж, байгууллагын соёлыг төлөвшүүлэхэд тодорхой ахиц гарсан байх
- Ажлын байранд шаардагдах мэдлэг, ур чадвар, мэргэшлийн түвшин боловсролын зэргийг дээшлүүлсэн байх

2.3.2. **“Оны шилдэг их эмч”**-ээр дор дурдсан болзлыг хангасан их эмчийг шалгаруулна.

- Тухайн жилд бүтээлч, шинэ дэвшилтэт технологийг тусламж, үйлчилгээнд нэвтрүүлэн, үр дүнг тооцож чанарын ахиц гаргасан байх
- Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний ачааллыг дааж, тусламж үйлчилгээ үзүүлсэн үйлчлүүлэгчийн тоо, цар хүрээгээр бусдыгаа манлайлан ажилласан байх
- Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг үзүүлэхэд санаачлагатай ажиллаж үр дүнд хүрсэн байх
- Үзүүлж буй эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмж нь үйлчлүүлэгчдийн талархал дэмжлэг хүлээсэн байх

- Хариуцсан ажлын эрүүл мэндийн үзүүлэлтүүд нь сайжирч, улс, аймгийн түвшинг хангасан байх
- Байгууллага нэгжийн хэмжээнд ажлаараа тэргүүлсэн байх
- Шинэ залуу эмч мэргэжилтнийг сургах, дадлагажуулахад санаачилгатай ажилласан байх
- Анхан шатны бүртгэл, маягтыг бүрэн, үнэн, зөв бүртгэж хэвшсэн байх
- Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээг сахиж, гомдол, чирэгдэлгүй ажилласан байх
- Ажлын байранд шаардагдах мэдлэг, ур чадвар, мэргэшлийн түвшин, боловсролын зэргийг дээшлүүлсэн байх

2.3.3. **“Оны шилдэг багийн эмч”**-ээр дор дурдсан болзлыг хангасан бага эмчийг шалгаруулна.

- Багийн иргэдэд хүрч үйлчлэх тусламж, үйлчилгээгээр бусдыгаа манлайлан, иргэддээ хамгийн ойр дөт үйлчилгээг хүргэж чадсан байх
- Үзүүлж буй эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмж нь багийн иргэдийн талархалыг хүлээсэн байх
- Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг үзүүлэхэд түлхүү анхаарч, санаачлагатай ажилласан байх
- Багийн иргэдийн эрүүл мэндийн чанарын үзүүлэлтүүд нь сайжирч, улс, аймгийн түвшинг хангасан байх
- Анхан шатны бүртгэл, маягтыг бүрэн, үнэн, зөв бүртгэж хэвшсэн байх
- Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээг сахиж, гомдол, чирэгдэлгүй ажилласан байх
- Ажлын байранд шаардагдах мэдлэг, ур чадвар, мэргэшлийн түвшин, боловсролын зэргийг дээшлүүлсэн байх

2.3.4. **“Оны шилдэг эх баригч”** -аар дурдсан болзлыг хангасан эх баригч бага эмчийг шалгаруулна.

- Жирэмсний давхар хяналтын тогтолцооны журмыг мөрдөж, эрт үеийн хяналтыг 90-ээс доошгүй хувьд хүргэж, жирэмсний хяналтын чанарыг сайжруулсан байх
- Жирэмсний ноцтой хүндрэл гараагүй байх
- Эх, нярайн эндэгдэлгүй байх
- Эх барихын тусламж үйлчилгээ болон нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд шинэ санаа, санаачлага нэвтрүүлж, үр дүнг тооцсон байх

- Үзүүлж буй эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмж нь иргэдийн талархалыг хүлээсэн байх
- Анхан шатны бүртгэл, маягтыг бүрэн, үнэн, зөв бүртгэж хэвшсэн байх
- Ажлын байранд шаардагдах мэдлэг, ур чадвар, мэргэшлийн түвшин, боловсролын зэргийг дээшлүүлсэн байх
- Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээг сахиж, гомдол, чирэгдэлгүй ажилласан байх

Жич: Үзүүлж буй эрүүл мэндийн тусламж үйлчилгээний тоо, цар хүрээг харгалзана.

2.3.5. **“Оны шилдэг сувилагч”**-аар дор дурдсан болзлыг хангасан сувилагчийг шалгаруулна

- Шинэ санаачилга, бүтээл ажилдаа нэвтрүүлж, үр дүнг тооцож, үнэлгээ өгсөн байх
- Сувилахуйн бие даасан болон багаар үзүүлсэн сувилахуйн тусламж үйлчилгээ, гэрийн сувилгаа үзүүлсэн байдал
- Онол практикийн бага хурал, ажил мэргэжлийн уралдаан тэмцээнд идэвхитэй оролцсон байх
- Анхан шатны бүртгэл, маягтыг үнэн, зөв бүртгэж хэвшсэн байх
- Ажлын байранд шаардагдах мэдлэг, ур чадвар, мэргэшлийн түвшин, боловсролын зэргийг дээшлүүлсэн байх
- Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээг сахиж, гомдол, чирэгдэлгүй ажилласан байх

2.3.6. **“Оны шилдэг лабораторын мэргэжилтэн”** -аар дор дурдсан болзлыг хангасан ажилтныг шалгаруулна

- Лабораторийн үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлж, хүртээмжийг сайжруулж ажилласан байх
- Лабораторын тусламжийг хөгжүүлэхэд тодорхой хувь нэмэр оруулсан байх
- Онол практикийн бага хурал, ажил мэргэжлийн уралдаан тэмцээнд идэвхитэй оролцсон байх
- Лабораторын шинжилгээний тоо, цар хүрээгээр бусдыгаа манлайлан ажилласан байх
- Анхан шатны бүртгэл, маягтыг бүрэн, үнэн, зөв бүртгэж хэвшсэн байх

- Ажлын байранд шаардагдах мэдлэг, ур чадвар, мэргэшлийн түвшин, боловсролын зэргийг дээшлүүлсэн байх
- Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээг сахиж, гомдол, чирэгдэлгүй ажилласан байх

2.3.7. **“Оны шилдэг эмийн мэргэжилтэн”** -ээр дор дурдсан болзлыг хангасан ажилтныг шалгаруулна

- Эмийн сангийн стандартын хэрэгжилтийг 90-ээс дээш хувь хангаж ажилласан байх
- Үйлчлэх хүрээний хүн амыг үндэсний зайлшгүй шаардлагатай эмээр тасралтгүй хангаж ажилласан байх
- Амин чухал эмийн хангалтыг 95-аас доошгүй хувь хангаж ажилласан байх
- Эмийн сангийн тохижилт, үйлчилгээгээр бусдыгаа манлайлан ажилласан байх
- Иргэдэд эмийг жороор үйлчлэх соёлыг төлөвшүүлсэн байх
- Иргэдийн эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлэхэд санаачлагатай ажилласан байх
- Иргэд, үйлчлүүлэгчийн сэтгэл ханамж эерэг байх
- ЭМГ-аас зохион байгуулсан арга хэмжээнд идэвхитэй оролцсон байх
- Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээг сахиж, гомдол, чирэгдэлгүй ажилласан байх
- Ажлын байранд шаардагдах мэдлэг, ур чадвар, мэргэшлийн түвшин, боловсролын зэргийг дээшлүүлсэн байх
- Санхүүгийн өр авлагагүй ажилласан байх

2.3.8. **“Оны шилдэг статистик мэдээллийн ажилтан”**-аар дор дурдсан болзлыг хангасан ажилтныг шалгаруулна

- Сарын мэдээг сар бүрийн 2-ны дотор үнэн зөв өгч, сарын мэдээний программд 3-ны дотор шивсэн байх
- Эх, хүүхдийн өвчлөл, эндэгдлийн долоо хоног бүрийн мэдээ, хүн амын төрөлт, нас баралтын баазыг тухай бүр, Эмчийн үзлэг, хүн амын өвчлөл, осол гэмтлийн мэдээллийн баазыг сар бүрийн 10-ны дотор холбогдох программд үнэн зөв шивсэн байх
- Анхан шатны маягтыг эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдээр бүрэн хөтлүүлж, гүйцэтгэлд нь тавих хяналтыг тогтмолжуулан заавар, зөвлөмжөөр хангаж ажилласан байх

- Анхан шатны бүртгэл маягтыг холбогдох тушаал, шийдвэрийн дагуу архивт хадгалж, хадгалалтын аюулгүй, бүрэн бүтэн байдлыг хангаж ажилласан байх
- Хүн амын өвчлөл, нас баралт, эрүүл мэндийн үзүүлэлтээр сар бүр мэдээлэл бэлтгэж, байгууллагын эмч, мэргэжилтэн, сумын удирдлага, хэрэглэгчдийг хэрэгцээт, нотолгоот мэдээллээр тухай бүр хангаж ажилласан байх
- Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээг сахиж, гомдол, чирэгдэлгүй ажилласан байх

2.3.9. **“Оны шилдэг нийгмийн эрүүл мэндийн ажилтан”** -аар дор дурдсан болзлыг хангасан ажилтныг шалгаруулна

- Нийгмийн эрүүл мэндийн хөтөлбөр, стратегийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, үр дүнг тооцсон байх
- Нийгмийн эрүүл мэндийн үйлчилгээнд шинэ санаачилга гарган ажиллаж, үр дүнг тооцсон байх;
- Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд хамрагдсан хүний тоо, цар хүрээг урд оноос ахиулж, бусдыгаа манлайлсан байх
- Ажлын байранд шаардагдах мэдлэг, ур чадвар, мэргэшлийн түвшин, боловсролын зэргийг дээшлүүлсэн байдал
- Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээг сахиж, гомдол, чирэгдэлгүй ажилласан байх
- Үйлчлэх хүрээний хүн амын эрүүл мэндийн чанарын гол үзүүлэлт улс аймгийн түвшинд байх

2.3.10. **“Оны шилдэг жолооч”** -аар дор дурдсан болзлыг хангасан ажилтныг шалгаруулна

- Хариуцсан автомашины бүрэн бүтэн байдал, засвар үйлчилгээг тогтмол сайн хийдэг байх
- Эмнэлгийн яаралтай тусламжийн үйлчилгээнд хугацаа алдсан тохиолдол гаргаагүй байх, үүргээ бүрэн биелүүлсэн байх
- Шатахууныг нормын дагуу зарцуулж, тайлан тооцоог хугацаанд нь тогтмол өгдөг байх
- Эрүүл мэндийн мэдлэг, мэдээллийн талаар тодорхой мэдлэгтэй байх, нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд тодорхой хувь нэмэр оруулсан байх,

- Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээг сахиж, гомдол, чирэгдэлгүй ажилласан байх

2.3.11. **“Оны шилдэг тогооч”** -оор дор дурдсан болзлыг хангасан ажилтныг шалгаруулна

- Эмнэлгийн хоолны цэсээр өвчтөнд тохирсон хоолоор үйлчилдэг байх,
- Гал тогооны эрүүл ахуйн дэглэмийг баримтлан холбогдох эрх зүйн актыг хэрэгжүүлж ажилладаг байх,
- Зөв, зохистой хооллолтын талаар сургагдаж, мэдлэг, ур чадвараа ахиулсан,
- Үр ашигтай, санаачлага гарган ажилласан,
- Эрүүл мэндийн мэдлэг, мэдээллийн талаар тодорхой мэдлэгтэй байх, нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд тодорхой хувь нэмэр оруулсан байх,
- Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээг сахиж, гомдол, чирэгдэлгүй ажилласан байх, иргэд үйлчлүүлэгчдийн талархлыг хүлээсэн байх,

2.3.12. **“Оны шилдэг үйлчлэгч”** -аар дор дурдсан болзлыг хангасан ажилтныг шалгаруулна

- Байгууллагын эрүүл ахуй, халдвар хамгааллын дэглэмийг баримталж, холбогдох эрх зүйн актыг хэрэгжүүлж ажилладаг байх
- Байгууллагын өнгө үзэмж, тохижилт, соёлжилтийг сайжруулах талаар бүтээлч санаачлага өрнүүлэн ажилласан байх,
- Үйлчлүүлэгчдийн судалгаагаар хариуцсан ажлын үнэлгээ эерэг, сайн байх,
- Үйлчилгээний соёлыг дээдлэх, үйлчлүүлэгчийг угтах соёлыг дээдэлж ажилладаг,
- Эрүүл мэндийн мэдлэг, мэдээллийн талаар тодорхой мэдлэгтэй байх, нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд тодорхой хувь нэмэр оруулсан байх,
- Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээг сахиж, гомдол, чирэгдэлгүй ажилласан байх

2.3.13. **“Оны шилдэг түшээ”** -ээр дор дурдсан болзлыг хангасан ажилтныг шалгаруулна

- Хариуцсан ажлын чанарын гол үзүүлэлтүүд улс, аймгийн түвшинд байх

- Онцлог, үр дүнтэй ажлыг зохион байгуулалтын өндөр түвшинд гүйцэтгэсэн байх
- Нэгж байгууллагуудаас эерэг үнэлгээтэй байх
- Мэргэжил арга зүйн туслалцааг газар дээр нь үзүүлсэн нэгж байгууллагын тоог харгалзах
- Баримт бичгүүдийн боловсруулалт стандарт, журмыг баримталсан байх
- Ажлын байранд шаардагдах мэдлэг, ур чадвар, мэргэшлийн түвшин, боловсролын зэргийг дээшлүүлсэн байдал
- Ёс зүйн алдаа зөрчил гаргаагүй байх;

2.3.14. **“Оны шилдэг санхүүч”**-аар дор дурдсан болзлыг хангасан ажилтныг шалгаруулна

- Өр авлага үүсгээгүй, үр ашигтай ажилласан байх
- Аудитын зөрчилгүй, төсвийн төслийг урьд оноос бууруулаагүй ЭМЯ-нд хамгаалж, батлуулсан.
- Санхүүгийн тайлан мэдээг хугацаанд нь үнэн зөв гаргаж, тайлагнасан байх
- Шилэн дансны мэдээллийг илгээх, байршуулах талаар зөрчилгүй байх
- Ажлын байранд шаардагдах мэдлэг, ур чадвар, мэргэшлийн түвшин, боловсролын зэргийг дээшлүүлсэн байдал
- Ёс зүйн алдаа зөрчил гаргаагүй байх;

2.4. Эрүүл мэндийн салбарын **“Оны шилдэг байгууллага”**:

2.4.1. **“Оны тэргүүний “Чанарыг эрхэмлэгч” байгууллага”**-аар дор дурдсан болзлыг хангасан эмнэлгийг шалгаруулж шагнана.

- Тухайн жилийн зорилт, үйл ажиллагааны үр дүн, гэрээний үнэлгээ “А”-ээс дээш үнэлгээтэй байх
- Хүн амын эрүүл мэндийн үзүүлэлтүүд аймгийн дунджаас дээгүүр түвшинд байх
- Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанарыг сайжруулах чиглэлээр тодорхой ажил зохион байгуулж үр дүнд хүрсэн байх
- Ажлын байрны таатай орчин бүрдсэн, ажлын байран дээр сурч хөгжих боломж бүрдүүлсэн байх
- Төсвийн өр авлагагүй ажилласан байх
- Байгууллага хамт олноороо ёс зүйн алдаа зөрчилгүй ажиллаж, байгууллагын соёлыг дээшлүүлэхэд тодорхой ахиц гарсан байх;

2.4.2. “Шилдэг менежменттэй байгууллага”- аар дор дурдсан болзлыг хангасан эрүүл мэндийн байгууллага, хамт олныг шалгаруулна

- Тухайн жилийн зорилт, үйл ажиллагааны үр дүн “А” үнэлгээтэй байх
- Байгууллагаа хөгжүүлэх, тусламж үйлчилгээний чанарыг сайжруулах талаар удирдлагын оновчтой арга хэлбэрийг сонгон хэрэгжүүлж үр дүнд хүрсэн байх
- Байгууллагын соёл, удирдлага зохион байгуулалт, үйл ажиллагааны талаар ажиллагсад, иргэдээс санал авч үйл ажиллагаандаа тусган хэрэгжүүлсэн байх
- Байгууллагын ажилтнуудын гүйцэтгэлийг үнэлэх, урамшуулах механизм бий болгон хэрэгжүүлсэн байх
- Байгууллагын хүний нөөцийг хөгжүүлэх, бэхжүүлэх төлөвлөгөөтэй ажиллан энэ чиглэлээр орон нутгийн төрийн болон ТББ, иргэдийн дэмжлэг туслалцааг авдаг байх
- Ажилтнуудыг сургах, мэдээллээр хангах боломж нөхцлийг бүрдүүлэх талаар санаачилгатай ажилласан байх
- Ажлын байрны эрүүл ахуй, аюулгүй байдлыг хангасан байх

2.4.3. “Байгууллагын соёл, ёс зүйг дээдлэгч үйлчилгээтэй байгууллага”- аар дор дурдсан болзлыг хангасан эрүүл мэндийн байгууллага, хамт олныг шалгаруулна.

- Ёс зүйтэй, зөв мэргэжилтнүүдийг төлөвшүүлэх бодлого үйл ажиллагааг хэрэгжүүлж, үр дүнд хүрсэн байх
- Байгууллагын дотоод журам, хөдөлмөрийн гэрээ, ажлын байрны тодорхойлолтоо боловсронгуй болгож эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээний асуудлыг тусгаж хэвшүүлсэн байх
- Эмнэлгийн тусламж үйлчилгээг ээлтэй, тохилог орчинд, ил тод, нээлттэй, чирэгдэлгүй үзүүлж үйлчлүүлэгчийг дээдэлдэг байх
- Эмнэлгийн тусламж үйлчилгээний талаар үйлчлүүлэгчдээс асуумж судалгаа авч, дүгнэлт хийж ажилласан байх
- Хууль тогтоомж, тушаал шийдвэрийн биелэлт, эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн асуудлаар тухайн жилд ямар нэг зөрчил гаргаагүй байх

2.4.5. “Эх, хүүхдэд ээлтэй эмнэлэг”-ээр дор дурдсан болзлыг хангасан эмнэлгийг шалгаруулна.

- Эх хүүхдийн эрүүл мэндийг хамгаалах, эх хүүхдийн эндэгдэл гаргахгүй байх талаар өөрийн байгууллага, орон нутгийн онцлогт тохирсон бодлоготой байж, хэрэгжилт үр дүнг тогтмол тооцож ажилласан байх
- Уг бодлогыг хэрэгжүүлэхэд зайлшгүй шаардлагатай ур чадварыг олгох сургалтанд эмнэлгийн бүх ажилчдыг хамруулж, сургалтын үр дүнг тооцсон байх;
- Жирэмсэн, төрөх, төрсний дараахь хүндрэл буурч, аймгийн үзүүлэлтээс бага байх;
- Жирэмснийг эрт илрүүлэх, эх хүүхдийн хоол тэжээлийн талаар зөвөлгөө өгөх эрүүл мэндийн сайн дурын туслахуудыг сургаж бэлтгэсэн байх;
- НҮЭМ болон эх, хүүхдийн эрүүл мэндийг дэмжих үйл ажиллагаанд иргэд хамт олныг өргөнөөр татан оролцоолж, мэдээлэл сургалт, сурталчилгаанд хамрагдсан иргэдийн тоо урд оноос нэмэгдсэн байх
- Тухайн жилд эх, хүүхдийн эндэгдэл гаргаагүй байх

2.5. Эрүүл мэндийн газрын **“Хүндэт өргөмжлөл”**-ийг дор дурдсан байууллага, хувь хүнд олгоно.

- Эрүүл мэндийн салбарыг хөгжүүлэхэд хувь нэмэр оруулж хамтран ажилласан байгууллага, хувь хүн

Гурав. Шагналд нэр дэвшүүлэх, уламжлах

- 3.1. Эрүүл мэндийн байгууллагууд энэ журамд заасан шагналд нэр дэвшигч эмч мэргэжилтэний тодорхойлолтыг журмын 3.2-т заасан тэмдэглэлт өдөр болохоос 20 хоногийн өмнө холбогдох материалын хамт Эрүүл мэндийн газарт ирүүлнэ.
- 3.2. “Хүндэт тэмдэг”, “Аймгийн эрүүл мэндийн тэргүүний ажилтан” цол тэмдэг, “Жуух бичиг” зэрэг шагналуудыг жил бүрийн сар шинийн баяр, эрүүл мэндийн салбарын ажилтны өдөр, шинэ жилийн баяр, байгууллагын ой зэрэг онцлог үйл явдлыг тохиолдуулан Эрүүл мэндийн газрын даргын тушаалаар олгоно.
- 3.3. “Оны шилдэг” эрүүл мэндийн ажилтнуудыг жил бүрийн шинэ жилийн баяраар шалгаруулж, Эрүүл мэндийн газрын даргын тушаалаар баталгаажуулж, алдаршуулна.

Дөрөв. Дагалдах шагнал

- 4.1. “Аймгийн эрүүлийг хамгаалахын тэргүүний ажилтан” цол, тэмдгийг 20000 төгрөгийн мөнгөн шагнал дагалдах ба дагалдах шагналыг үндсэн байгууллагаас нь олгоно.
- 4.2. Оны шилдэг эрүүл мэндийн ажилтанд үндсэн цалингийн 20 хувиар 3 сар нэмэгдүүлэн олгох ба урамшуулалт цалинг тухайн байгууллагаас нь олгоно.
- 4.3. Оны шилдэг байгууллагыг үнэ бүхий шагналаар шагнана. Шагналыг ЭМГ хариуцна.

Б.УРАМШУУЛАЛ

Алслагдсан сум багт олон жил тогтвор суурьшилтай, үр бүтээлтэй ажиллаж, эрүүл мэндийн тусламж үйлчилгээг чанартай, хүртээмжтэй хүргэж, хөдөөгийн хүн амын эрүүл мэндийг хамгаалах үйлсэд амжилттай ажилласан эмч, мэргэжилтнийг жил бүр урамшуулна. Урамшууллын зардлыг ЭМГ хариуцна.

Нэг. Урамшууллын төрөл

- 1.1 Рашаан сувилалд амрах эрхийн бичиг
- 1.2 Туршлага судлуулах, байгалийн үзэсгэлэнт газраар аялах эрхийн бичиг
- 1.3 Хөрш зэргэлдээ болон гадаад оронд туршлага судлуулах

Хоёр. Урамшуулал олгох болзол

- 2.1 Алслагдсан сум багт 15-с дээш жил тогтвор суурьшилтай ажилласан.
- 2.2 Ёс зүйн болон мэргэжлийн алдаа дутагдал гаргаж байгаагүй.
- 2.3 Хариуцсан ажлын үзүүлэлтүүд нь сүүлийн жилүүдэд тогтвортой сайжирсан.

-----oOo-----